



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/508

Чойбалсан

Г Тээврийн түр чиглэл батлах тухай

7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.21, 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Автотээврийн тухай хуулийн 7.1.4, Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8, 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Шинь Шинь" ХХК-аас 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн d-25-340 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/491 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлтийн дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших "Шинь Шинь" ХХК, Улааны холимог металын орд газраас Галын голын гүүр- Чойбалсан сумын Энгэр шандын 3-р багийн нутагт орших "ЭН И СИ" ХХК-ийн тээвэрлэлтийн орон нутгийн чанартай авто зам хүртэл 120км байхаар түр авто замын чиглэлийг тогтоосугай.

2. Батлагдсан авто замын чиглэлийн дагуу тээвэрлэлт гүйцэтгэхдээ Автотээврийн хэрэгслийн ангилал, "Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2025, "Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлага" стандарт, норм, дүрмийг чанд мөрдөн ажиллахыг "Шинь Шинь" ХХК-д даалгасугай.

3. Дээрх авто замын засвар арчлалтыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, дэвшилтэд арга технологийг ашиглан хүн, мал, амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөхүйц тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэн, газрын хөрсийг хамгаалж олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэлтийг гүйцэтгэн, жолоочийн амрах цэг, ариун цэврийн байгууламж болон хог хаягдал цуглуулах цэгийг авто зам дагуу байгуулж ажиллахыг "Шинь Шинь" ХХК-д үүрэг болгосугай.

4. Ачаа тээвэрлэлт, авто зам ашиглалтад холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Эрдэнэбаатар), Авто замын хяналтын улсын байцаагч (М.Ганбат), аймгийн Автотээврийн төвийн дарга (Ц.Мөнхтөр), аймгийн Байгаль орчны газрын дарга (А.Гантулга), Чойбалсан сумын засаг дарга (Г.Төрболд) нарт тус тус даалгасугай.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁП